



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 01

Ховд

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл,
хяналтыг сайжруулах тухай

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, өмч бүртгэл болон тайлагналтын явцад төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны зохион байгуулалт сул, холбогдох албан тушаалтнуудын буруутай үйлдлүүдээс шалтгаалан алдаа, дутагдал удаа дараа гарч байгаа тул хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын чанар, үр дүнг сайжруулах зорилгоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газарт:

- 1.1. Тухайн жилийн орон нутгийн төсвийн төслийг боловсруулахдаа хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан, иргэдийн саналд үндэслэсэн, техник эдийн засгийн үндэслэл, зураг, төсөвтэй хөрөнгө оруулалтуудыг төлөвлөж байх;
- 1.2. Хөрөнгө оруулалтын ажлын даалгаврыг боловсруулахдаа тухайн ажилтай холбоотой мэргэжлийн байгууллага, холбоодын саналыг үндэслэх;
- 1.3. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийг сонгох арга зүйг боловсронгуй болгож, инженер, техникийн ажилтнуудыг түлхүү оруулах, арга зүйн сертификаттай хүний нөөц бэлтгэх арга хэмжээ авах;
- 1.4. Үнэлгээний хороо байгуулахад мэргэжлийн төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллах;
- 1.5. Захиалагчийн явцын хяналтыг сайжруулж, газар дээр нь ажлын явцыг бодитоор үнэлж байх, хөрөнгө оруулалтын үе шат бүрийн гүйцэтгэлд тавих хяналтыг хуваарьт оруулан баталж, хэрэгжүүлж, тайлагнах;
- 1.6. Хөрөнгө оруулалтыг хүлээн авах ажлыг иргэд, олон нийтэд нээлттэй зарлаж, иргэдийг сайн дурын үндсэнд оролцуулах арга хэмжээ авах;

8407702 0301
2024 AD/01 Ba

Хоёр. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн явцын хяналт, хүлээн авах улсын комиссын ажлын чанарыг сайжруулах;

2.2. Хөрөнгө оруулалтыг хүлээн авах ажлыг иргэдэд нээлттэй зарлаж, иргэдийг сайн дурын үндсэнд оролцуулах арга хэмжээ авах;

Гурав. Сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч, дарга нарт:

3.1. Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан салбарын хөрөнгө оруулалттай холбоотой саналыг ирүүлэхдээ техник эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв, арга хэмжээнд тавигдах шаардлагыг бүрэн хангасан санал ирүүлж байх;

3.2. Хөрөнгө оруулалтын хяналтын чанар, үр дүнг дээшлүүлэхэд анхаарч, явцын хөндлөнгийн хяналтыг сайжруулах;

3.3. Хөрөнгө оруулалтын тайлагналт, ашиглалтын үр дүнг сайжруулах;

3.4. Хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналт тавихад оролцож буй албан тушаалтан, алба хаагчдыг төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг чанд мөрдөх, бусад хууль тогтоомжоор зохицуулсан ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх;

3.5. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын талаар иргэдээс авах саналыг чанартай зохион байгуулж, журмын хэрэгжилтийг хангах;

3.6. Хөрөнгө оруулалтын үр дүнг ил тод мэдээлэх;


3.7. Улсын болон орон нутгийн төсвөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээ, тоног төхөөрөмж, их засвар, барилга, байгууламжийн холбогдох техникийн нөхцөл, газар чөлөөлөлт, зураг төсөв батлуулах, ажлын даалгавар боловсруулах зэрэг ажлуудыг холбогдох стандартын дагуу төлөвлөсөн цаг хугацаанд хариуцлагатай хэрэгжүүлж ажиллах;

Дөрөв. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих

4.1 Хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан холбогдох журмын дагуу тооцож, тайланг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд)-д үүрэг болгосугай.

4.2. Албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА